СЭЛЭНГЭ АЙМАГ ОРХОН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 16 өдөр Дугаар 36 Нарт

Үндсэн чиглэл батлах тухай

Сумын 2019 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай сумын Засаг даргын орлогч Г.Баасансүрэнгийн илтгэлийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанаар хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын "а" заалтыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.

2.Сумын эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажил үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр гаргаж сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнахыг сумын Засаг дарга /Г.Бат-Орхон/-д даалгасугай.

ДАРГА Х.МӨНХЗУЛ

Сэлэнгэ аймаг Орхон сумын ИТХ-ын 2018 оны
11-р сарын 16-ны өдрийн 36 тоот тогтоолын хавсралт

## СЭЛЭНГЭ АЙМАГ ОРХОН СУМЫН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙГ 2019 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| № | № | Үндэслэсэн дунд хугацааны бодлогын баримт бичиг | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | | Хариуцах байгууллага | Хяналт тавьх байгуул -лага |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Одоогийн байдал | Хүрэх үр дүн | | |
| **НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **1.1 Эрүүл мэндийн бодлого** | | | | | | | |
| **МУЗГ, аймаг сумаас хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:** | | | | | | | |
| 1 | 1 | МУЗГҮАХ-ийн 3.1.5 | “Эрүүл мэндийг дэмжигч ААН байгууллага”, “Эрүүл мэндийг дэмжигч айл өрх”, “Эрүүл мэндийг дэмжигч анги”, “Эрүүл мэндийг дэмжигч иргэн”-шалгаруулах болзолт уралдааныг тогтмолжуулж чанаржуулна. | Эрүүл мэндийн сайдын 2002 оны 176 тоот тушаал байдаг. Болзолт уралдааны үйл ажиллагаа тогтмол биш, 2016 онд шалгаруулаагүй. | Эрүүл мэндийг дэмжигч ААН, байгууллага, иргэн, айл өрх, ангитай болсон байна. Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна. | ЭМТөв | ЗДТГ |
| 2 | 2 | МУЗГҮАХ-ийн 3.1.6, СЗДҮАХ-ийн 1.1.3 | “Сүрьеэгүй Сэлэнгэ” хөтөлбөрийн хүрээнд “Сүрьеэгүй Орхон” уриан дор хавьтлын судалгааг гаргаж, эрт илрүүлэх, оношлох үйл ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулна | Сүрьеэг илрүүлэхэд нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлд харъяалагдах эрх бүхий гишүүд болон иргэдийн оролцоо дутмаг байна. 2018 онд сүрьеэгийн хяналтанд 2 өвчтөн үргэлжлэх шатны эмчилгээтэй байна. | Сүрьеэгийн тархалтыг зогсооно. “Сүрьеэгүй Орхон” уриан дор хавьтлуудыг өвчлөхөөс урьдчилан сэргийлнэ. | ЭМТөв | ЗДТГ |
| 3 | 3 | СЗДҮАХ-ийн 1.1.3 | “Амны хөндийн эрүүл мэнд”-хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт | Амны хөндийн хөтөлбөр одоогийн байдлаар эмчилж эрүүлжүүлэх үзлэг | Шүд цооролтын тархалтыг 30% болгож бууруулж | ЭМТ, XII цэцэрлэг | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тавьж, эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулна. | хангалтгүй, нарийн мэргэжлийн эмчийг ажиллуулах төсөв, тоног төхөөрөмж байхгүй, одоогийн түвшин шүд цоорoлтын тархалт 37,7% байна. | ажиллана. | ЕБС | |
| 4 | 4 | СЗДҮАХ-ийн 1.1.2, 1.1.5 | Сумын хэмжээнд "Тэгш дүүрэн" хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулж, сэргээн засах кабинетийн өрөөг тохижуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд, сэргээн засан тусламж үйлчилгээг үзүүлнэ. | ЭМС-ын 2011.07.01 216 тоот тушаал "Тэгш дүүрэн хөтөлбөр" хэрэгжилтэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчин дутмаг, тусламж үйлчилгээ үзүүлэх өрөөний тохьжилт хангалтгүй. /массажны сандал, усан эмчилгээний ванн/ одоо байгаа төхөөрөмжүүд ажиллах боломжгүй. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хамт олны оролцоо нэмэгдэж, өрөөний орчин нөхцлийг сайжруулж, үйлчилгээний чанар хүртээмж сайжирна. | ЭМТөв | ЗДТГ |
| **Хүн амыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоо, эрт илрүүлгийн ажлын чанарыг сайжруулах талаар:** | | | | | | | |
| 5 | 5 | МУЗГҮАХ-ийн 3.1.2, АЗДҮАХ-ийн 2.1.3, 2.1.5, 2.1.9, СЗДҮАХ-ийн 1.1.6 | Хүн амын урьдчилан сэргийлэх үзлэгийн чанарыг сайжруулах талаар:<br>1. ХДХВ/ДОХ, БЗДХ өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх<br>2. 0-5 хүртэлх насны хүүхэд болон эх нялхсын эрүүл мэнд<br>3. Хөх болон умайн хүзүүний хавдар, элэгний хавдар, артерийн даралт, чихрийн шижин хэв шинж-2 эрт илрүүлгийн | Сумын нийт 16-54 насны 1359 хүнээс 372 хүнийг 27%-тай хамрагдсан.<br>1.ХДХВ/ДОХ-ын өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.<br>2. 2018 онд 0-5 хүртэлх насны хүүхдийн үзлэг шинжилгээ, дархлаажуулалт тогтмол хийж хэвшсэн<br>3. Хөх болон умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн үзлэг 72%, элэгний хавдрын эрт илрүүлгийн үзлэг 70%, чихрийн шижин хэв шинж-2 | Эрт илрүүлгийн үзлэгийн хувийг 50%-д хүоч урьдчилан сэргийлэх ажил ахиц гарна.<br>1.<br>2.Төмрийн бэлдмэл, бичил тэжээл, Д-витаминаар хангагдаж, эх нярайн эндэгдэлгүй, өвчлөлийн статистик үзүүлэлт өмнөх оноос буурсан байна.<br>3. Халдварт бус | ЭМТөв | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажлыг эрчимжүүлж, иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлж чанаржуулна. 4. Хүн амын бие бялдрын сорилыг насанд хүрэгчдийн түвшинд 70 хувьд хүргэнэ. | 102%-тай байна. 4. Бие бялдрын чийрэгжилт, хөгжлийн түвшин тогтоох сорил авагддаг хэдий ч хангалттай түвшинд хүрэхгүй байна | өвчний эрт илрүүлгийн үзлэг шинжилгээг 100%-д хүргэнэ. Халдварт бус өвчний эрт илрүүлэг сайжирч, урьдчилан сэргийлнэ. 4. Иргэдийн бие бялдрын чийрэгжилтийн түвшинг тогтоосноор эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой | | |
| 6 | 6 | АЗДҮАХ-ийн 2.1.12 СЗДҮАХ-ийн 1.1.2 | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор жилд 2 удаа нэгдсэн арга хэмжээ, 2 удаа явуулын хэлбэрээр зохион байгуулна. | Эмийн зохистой хэрэглээний талаарх иргэдийн ойлголт дутмагаас антибиотекийн дасал болох, дур мэдэн эм хэрэглэж, өвчнөө хүндрүүлэх хандлагатай байна. | Иргэдийн эмийг зохистой хэрэглэх эрүүл зан үйл төлөвшсөн байна. | ЭМТөв | ЗДТГ |
| 7 | 7 | СЗДҮАХ-ийн 1.1.3 | Сумын хүн амыг нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд жилд 1-ээс доошгүй удаа хамруулж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна. | 2018 онд 2 удаагийн 14 төрлийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 942 иргэн хамрагдсанаар урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 84,6%-тай байна. | Эрт илрүүлгийн ажил эрчимжинэ. Нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийн чанар хүртээмж нэмэгдэнэ. | ЭМТөв | ЗДТГ |
| 8 | 8 | СДҮАХ-ийн 1.1.4 | Түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор сувилагчдын эрэмбэлэн ангилал | Одоогийн байдлаар түргэн тусламжийн 10 дуудлага тутмын 5 нь очих шаардлагагүй дуудлага | “Дуудлага хүлээн авах журам”-г мөрдөж хэвшсэн байна. | ЭМТөв | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хийх ур чадварыг сайжруулж дуудлага хүлээн авах журмыг мөрдүүлэх | байдаг ба эмч нар утсаар зөвлөгөө өгч шийдвэрлэдэг. | | | |
| | **Иргэдийн саналыг үйл ажиллагаандаа тусган ажиллах талаар:** | | | | | | |
| 9 | 9 | Иргэдийн санал | Эмч эмнэлгийн ажилчдын дунд 4 үе шаттай дотоод ажил зохион байгуулж эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. | Энэ төрлийн үйл ажиллагаа өмнө зохион байгуулагдаж байгаагүй. | Ажлын зохион байгуулалт сайжирч ЭМТ-ийн үйлчилгээний чанар хүртээмжид ахиц гарна. | ЭМТөв | ЗДТГ |
| 10 | 10 | Иргэдийн санал | Дотоод нөөц боломжийнхоо хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:<br><br>1.ЭМТ-ийн гадна хашааг цэцэрлэгжүүлж мод тарих, авто машины зогсоолын арын талбайг засварлах<br>2. Граж болон моргийн барилгын цахилгааны монтаж, шинэчлэх<br>3. Бэлэндалай багийн эмчийн байранд урсгал засвар хийх | 1. Авто машины зогсоолын ар хэсэг нь хатуу хучилтгүй учир шороо, цас, ус урсаж зам талбайг бохирдуулдаг.<br><br>ЭМТ-ийн хашаанд цэцгийн 12 мандал, чацаргана-6, монос-2, хайлаас-6, улиас-6 ширхэг ургаж байна.<br>2. Граж моргийн барилгын цахилгаан нь гэмтэлтэй, дээврийн засвараас хойш тасарсан.<br>3. Багийн эмчийн байрыг ашиглалтанд орсноос хойш засвар хийгдээгүй бөгөөд шал дээвэр нь мөөгөнцөртөж муудсан. | 1. ЭМТ-ийн эзэмшил газарт ногоон байгууламж нэмэгдэж<br><br>байгууллагын өнгө үзэмж сайжирна.<br>2. Морг, гражийг ашиглах үед эрүүл аюулгүй нөхцөл бүрдэж цахилгааны гэмтэлгүй болсон байна.<br>3. Багийн эмчийн байрны засвар хийгдэж 2-р багийн иргэдэд хүрч үйлчлэх нөхцөл сайжирна. | ЭМТөв | ЗДТГ |
| **1.2 Боловсролын бодлого**<br>*Боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэн сурагчдын сурч боловсрох таатай орчин нөцөлийг бүрдүүлнэ.* | | | | | | | |
| | 1 | АЗДҮАХ-ийн 2.2.2 | Сургуулийн орчинд гэрэлтүүлэг, камер байршуулах | Гадна орчны гэрэлтүүлэг дутмаг, одоогоор камержуулалт үгүй. | Сургуулийн гадна орчинд сурагчдын аюулгүй байдал, замын хөдөлгөөний болон бусад | ЕБС | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | | | | | эрсдэлээс урьдчилан сэргийлэх, баримтжуулах боломж бүрдэнэ. | | |
| 12 | 2 | АЗДҮАХ-ийн 2.2.3 | “Эко сургууль”-ийн шалгуурт нийцүүлэн байгууллагын орчинд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх | Сургуулийн гадна, дотно орчны үнэлгээ хийж, эрсдлийг илрүүлсэн. | “Эко сургууль” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, сурагчдад ээлтэй орчин бүрдэнэ. | ЕБС | ЗДТГ |
| 13 | 3 | АЗДҮАХ-ийн 2.2.11 | ЕБС, СӨБ-ын Багш, ажилчдын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх зорилгоор төрөлжсөн болон бүсчилсэн сургалтанд тогтмол хамруулж ажиллана. | Тогтмол хамруулан ажиллаж байна | Багш нар цаг үеийн болон шинэ мэдээ мэдээлэл, сургалтын арга зүй, тэргүүн туршлагад суралцсан байна. | ЕБС | ЗДТГ |
| 14 | 4 | ЗГҮАХ-ийн 3.2.6, АЗДҮАХ-ийн 2.2.6 | Сургуулийн дотуур байрны эрүүл ахуйн орчин нөхцөлийг сайжруулж, хатуу эдлэлийг шинэчилнэ. | Сурагчдын хэрэгцээнд зориулагдсан ширээ, сандал, тавилга эд хогшил элэгдэж хуучирсан. | Дотуур байрны сурагчдын хэрэгцээнд зориулагдсан зарим хатуу эдлэл шинэчлэгдэнэ. | ЕБС | ЗДТГ |
| 15 | 5 | ЗГҮАХ 3.2.10 АЗДҮАХ 2.2.2, СЗДҮАХ-ийн 1.2.3 | Чадварт суурилсан сургалтын үйл ажиллагааг чанаржуулж, сонгон, секц, дугуйлангаар хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлсэн чадварлаг багш, иргэн, ААН, байгууллагыг урамшуулна. | Аймаг, бүсийн олимпиад, уралдаанд амжилттай оролцсон, ЭЕШ-ын хэмжээст оноогоор аймгийн дунджаас дээгүүр эрэмбэлэгдсэн багшийг урамшуулж байна. | Хүүхэд бүрийг жигд хөгжүүлэн тодорхой үр дүнд хүрсэн багш, иргэн ААН, байгууллагыг олон нийтэд таниулан сурталчилагдсан байна. | ЕБС | ЗДТГ |
| 16 | 6 | АЗДГ-ний 5 дахь заалт | Монгол хэл, гадаад хэлний хичээлийн олимпиадыг бүсийн хэмжээнд | Монгол хэл, гадаад хэлний хичээлийн олимпиадыг Орхон бүсийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын | Монгол хэл, гадаад хэлний хичээлийн олимпиадыг Орхон бүсийн хэмжээнд | ЕБС | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үргэлжлүүлэн зохион байгуулна. | нэрэмжит болгон санаачлан бүсийн хэмжээнд зохион байгуулж эхэлсэн. | зохион байгуулан тогтмолжуулснаар тус судлагдахууны чиглэлээр сургалтын чанар сайжирч, аймгийн төрөлжсөн олимпиадад амжилттай оролцоно. | | |
| 17 | 7 | СЗДҮАХ-ийн 1.2.10 Иргэдийн санал | Багийн цэцэрлэг болон зуны гэр цэцэрлэг, явуулын багшийн сургалт зэрэг олон хувилбарт сургалтаар дамжуулан СӨБ-ийн хамран сургалтыг нэмэгдүүлж ажиллана | 2018 онд 194 хүүхэд суралцахаас 12-р цэцэрлэгт 104, бусад аймаг суманд эцэг эхийн хамт түр оршин сууж СӨБ-д хамрагдаж буй 41 хүүхэд, СӨБ-ийн хамран сургалт 74.7 хувьтай байна. | Зуны улиралд малчид, ногоочдын хүүхдүүд СӨБ-д хамрагдаж хамран сургалт нэмэгдэнэ. | Цэцэрлэг БЗДарга нар | ЗДТГ |
| 18 | 8 | СЗДҮАХ-ийн 1.2.4 | “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” шалгуурт нийцүүлэн эмчийн өрөөны тохижилтыг сайжруулах | Дотоод зохицуулалт хийж эмчийн өрөөтэй болсон. Нэмж тохижуулах шаардлагатай. | Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгуур үзүүлэлт хангагдан хүүхдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх орчин нөхцөл сайжирсан байна | Цэцэрлэг | ЗДТГ |
| 19 | 9 | СЗДҮАХ-ийн 1.2.4 | Хүүхдийн сургалтын орчныг сайжруулах ажлын хүрээнд ширээ сандал бусад шаардлагатай хэрэглэгдэхүүнийг шинэчлэнэ. | Эцэг эхчүүдийн дэмжлэг туслалцаагаар эвдэрч элэгдэлд орсон ширээ сандалыг засч сэлбэх, шинэчлэх ажил хийгдэж байна. | Хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөл сайжирсан байна | Цэцэрлэг | ЗДТГ |
| 20 | 10 | | “Сумын хөгжилд хүүхдийн оролцоо” чуулганыг үргэлжлүүлэн зохион байгуулна. | 2017 онд хүүхдийн чуулганыг зохион байгуулж, “mini parlament”, цахим орчин зэрэг нийт 5 асуудлаар хэлэлцүүлэг | Хүүхдүүдээс гарсан санал санаачлагыг дэмжиж ажиллах, нийгмийг танин мэдэх зөв хандлага, | ЕБС, эцэг эхийн зөвлөл | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сургалт зохион байгуулж хүүхдийн дуу хоолойг сонсож ажилласан. | төлөвшил бий болно. | | |
| **1.3 Соёл урлагийн бодлого** | | | | | | | |
| 21 | 1 | СЗДҮАХ-ийн 1.2.10 | Орон нутаг сурталчлах танхимд “Байгалийн булан” шинэчлэн тохижуулж, хадгалалтыг сайжруулна. Ард иргэд, хүүхэд залуучуудыг түүх соёлоо мэддэг, нутаг орноороо бахархах үзлийг төлөвшүүлэн бүх нийтийн “Явган аялал”-ыг зохион байгуулах | 2018 онд Орхон нутгийн онцлогыг харуулсан нутгийн бренд Орхон хонь, газар тариалангийн буланг шинээр бий болгосон. | “Байгалийн булан” хийгдсэнээр ОНСТанхим бүрэн тохижиж сумын 60 жилийн ойг угтсан орон нутаг сурталчлах танхим дахь тохижилтын ажлууд дууссан байна. | Соёлын төв | ЗДТГ |
| 22 | 2 | СЗДҮАХ-ийн 1.2.11 | Малчид, тариаланчдад соёл урлагийн үйлчилгээг тодорхой удирдамжийн дагуу хүргэж хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2018 онд II багийн хурлыг хэсэгчилж хийх үеэр Ар булан, Цант, Шийр,42-р зөрлөг, Хар нүдэн, Мангирт хэсгийн малчин өрхүүдэд соёлын үйлчилгээг хүргэсэн. Малчин мал бүхий 210 өрх хамрагдсан. | Соёл урлагийн цогц үйлчилгээг малчид, тариаланчдад улиралд 1-2 удаа тогтмол хүргэж иргэдэд төрийн үйлчилгээг хүргэсэн байна. | Соёлын төв | ЗДТГ |
| 23 | 3 | СЗДҮАХ-ийн 1.3.2 | Бүжгийн дугуйлангийн үйл ажиллагааг тогтмолжуулж суралцагчдын тоог нэмэгдүүлнэ. | 2018 оны байдлаар бүжгийн дугуйланд 52 хүүхэд суралцаж байна. | Бүжгийн дугуйланд хичээллэгсдийн тоо нэмэгдэж хүүхэд залуучуудын авьяас чадварыг нээн илрүүлэх хөгжүүлсэн байна. | Соёлын төв | ЗДТГ |
| 24 | 4 | СЗДҮАХ-ийн 1.3.4 | Соёлын төвийн номын сангийн фондын баяжилтыг нэмэгдүүлэн уншигч бүрийг цахим карттай болгож үйл ажиллагааг сайжруулах | 2018 онд БСШУСЯамны санхүүжилтээр 1 сая төгрөгний ном нийлүүлэгдсэн. | Соёлын төвийн номын сангийн фондын баяжилтыг нэмэгдүүлэн, уншигч бүрийг цахим карттай болгон үйл ажиллагааг | Соёлын | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сайжруулсанаар иргэдэд шинэ ном товхимлоор тогтмол, түргэн шуурхай үйлчилж, олон төрлийн үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна. | төв | |
| 25 | 5 | СЗДҮАХ-ийн 1.3.5 | Соёлын төвд ажиллаж байсан ахмадууд болон ардын авьяастнуудын хамтарсан “Бид соёлынхон” тоглолт зохион байгуулна. | 2015-2017 оны хооронд 3 жил зохион байгуулагдсан. 2018 онд хийгдээгүй. | Соёлын төвийн үе үеийн ажилтнуудын ажлын уялдаа холбоо, ахмадын зөвлөх үйлчилгээ хамтын ажилагаа сайжирсан байна. | Соёлын төв | ЗДТГ |
| 26 | 6 | Иргэдийн санал | Тэмдэглэлт өдөр, баяр ёслолын бэлтгэл ажлыг ханган, өндөр түвшинд зохион байгуулна. | 2018 онд 14 удаагийн тэмдэглэлт өдөр баяр ёслол, 2 удаагийн аялан тоглолт, 3 кино үзвэр нийт нийт 19 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулагдсан. | Иргэдийн сэтгэл ханамж дээшилж тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээг олон нийтэд хүргэсэн байна. | Соёлын төв | ЗДТГ |
| 27 | 7 | Иргэдийн санал | Соёлын төвийн гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгэнэ. | Гадна гэрэлтүүлэг хангалтгүй, хашаа нэмж барих шаардлагатай, | Соёлын төвөөр үйлчлүүлэгчдийн орчин нөхцөл сайжирна | Соёлын төв | ЗДТГ |
| **1.4 Биеийн тамирын бодлого** | | | | | | | |
| 28 | 1 | СЗДҮАХ-ийн 1.4.2 | Бөхийн төрлийн секц дугуйланг хичээллүүлнэ. | Бөхийн төрлийн спортоор 2018 онд 3 удаагийн тэмцээн уралдаанд зохион байгуулагдсан. | Бөхийн спортоор хичээллэх хүүхэд залуучуудын тоо нэмэгдэнэ. Амжилт чанарын түвшин дээшилнэ. | Нарт-Орхон бөхийн дэвжээ | ЗДТГ |
| 29 | 2 | СЗДҮАХ-ийн 1.4.3 | Сумын Засаг даргын нэрэмжит “Сумын аварга шалгаруулах” олон төрөлт тэмцээнүүдийг зохион байгуулна. | 2018 онд 5 төрлийн тэмцээн зохион байгуулагдсан. | Иргэд нийтийн биеийн тамираар хичээллэж чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлнэ. | Ажлын хэсэг | ЗДТГ |
| | 3 | СЗДҮАХ-ийн | “Орхон бүс-2019” гар | 2017 оноос 3 дахь жилдээ | Б.Ганхуяг багшийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | | 1.4.5 | бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг Б.Ганхуяг багшийн нэрэмжит болгон зохион байгуулна. | уламжлал болон зохион байгуулагдаж байна. | суманд волейболын спортыг хөгжүүлэхэд оруулсан үйл хэргийг сурталчилан хүндэтгэл үзүүлсэн байна. | ЗДО | ЗДТГ |
| **1.5 □□□□□□өр □□□□□□□, □□□□□□□□ □□□□□□□□□ □ □□□□□□□□**<br>*Хөдөлмөрийн насны ажил, хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийг ажлын байраар хангаан орлогыг нэмэгдүүлж, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, □□□□□□ □□ □□□□□□□ □□□□□□□□□□□□□□□□□ □□□□□□ □□□□□□□□□□□ □□□□□□□на.* | | | | | | | |
| 31 | 1 | СЗДҮАХ-ийн 1.5.1 | Хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл, цахим мэдээллийн санг өргөжүүлэх, иргэдэд хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж ажилгүй иргэдийг ажилд зуучилна. | Сумын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй 49 иргэнийг цахим мэдээллийн санд бүртгүүлж 33 иргэн ажлын байранд зуучлагдан ажиллаж байна. Үүнээс төр төсвийн байгууллагад-16, шинээр ажлын байртай болсон 17 иргэн | Ажил хайгч иргэдийн цахим мэдээллийн санд бүртгэж ажилд зуучлах, төсөл хөтөлбөрт хамруулах ажил зохион байгуулсанаар ажилгүй иргэдийн тоо буурна. | НБХЭАХМ | ЗДТГ |
| 32 | 2 | СЗДҮАХ-ийн 1.5.2<br>АЗДҮАХ-ийн 2.6.13 | Бага орлоготой айл өрхийг төмс, хүнсний ногоо тариалах ажилд хамруулан туслах аж ахуйг эрхлүүлэх замаар ажлын байр, амьжиргааны эх үүсвэртэй болгоно. | Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт мод модон эдлэл, загасан бүтээгдэхүүн, цахим үйлчилгээ зоогийн газрын чиглэлээр 4 иргэн хамрагдсан. Бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах арга хэмжээнд сумдын ядуурлаас гаргах өрхийн гишүүдээс 2 өрхийг тус бүр 500.0 төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн. | Төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгээр хэлэлцэн зорилтот бүлгийн өрхийг төсөл хөтөлбөр болон НХА-д хамруулж ажлын байртай болоход дэмжлэг үзүүлнэ. | НБХЭАХМ ХХҮМэргэжилтэн | ЗДТГ |
| 33 | 3 | АЗДҮАХ-ийн 1.5.4, 1.5.10 | Байнгын асаргаанд байдаг ахмад настнуудын ар гэрт асаргааны сургалт зохион байгуулна. | Байнгын асаргаанд байгаа ахмад настны асран хамгаалагч нарт Эрүүл мэндийн төвтэй хамтран асаргаа сувилгааны болон сэтгэл санааны тайвшрал | Ахмад настнуудыг асарч буй иргэдэд асаргааны сургалтыг зохион байгуулна. Ахмад настан асарч байгаа иргэн асаргаа | Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | олгох арга зүйг танилцуулж Эрүүл мэндийн төвийн эмч сувилагчтай гэрээр очиж үзлэг хийж зөвөлгөө өгч ажилласан. | сувилгааны талаарх мэдлэг чадвар дээшилсэн байна. | | |
| 34 | 4 | СЗДҮАХ-ийн 2.1.14 | “Малжуулах “төсөл”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | 2018 онд 3 өрх малжуулах хөтөлбөрт хамрагдаж 5 тугалтай үнээгээр малжуулсан. | Малжуулах төслөөр дамжуулан зорилтот өрхийн амжиргаа дээшилсэн байна. | БЗД, ХХҮ-ний алба | ЗДТГ |
| 35 | 5 | АЗДҮАХ-ийн 3.3.14 | 3 хүртэл насны хүүхэдтэй ээжүүдийн нийгмийн баталгааг сайжруулах “Цалинтай ээж” хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа нь тасрахгүй байх эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 2018 оны байдлаар 0-3 насны хүүхэдтэй 136 ээж бүртгэлтэй. 100 хувь цалинтай ээж хөтөлбөрт хамрагдсан байна. | Цалинтай ээж хөтөлбөрийн хэрэгжиж нийгмийн баталгаа хангагдсан байна. | Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн | ЗДТГ |
| 36 | 6 | ИТХ-ийн төлөөлөгчийн санал | Татварт бүртгэлтэй аж ахуй нэгжийн судалгааг татварын байцаагчтай хамтран гаргаж нийгмийн даатгалд хамруулах, мөн шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн хариуцлагыг дээшлүүлж ажиллагсдыг нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах | Сумын Татварын албатай хамтран аж ахуй нэгжийн судалгааг гаргасан. Татварт бүртгэлтэй нийт 91 аж ахуй нэгж байна. Үүнээс үйл ажиллагаа явуулдаггүй -28, НДШ төлдөг – 32, НДШ төлдөггүй -31 ААН байна. 2018 онд “Бобб баян”ххк, “Шижир цагаан зам”ххк,”Шимт шийр” ББН-ийг нийгмийн даатгалд бүртгэж тайланг цахимаар авч баталгаажуулалт хийгдсэн. | ААН байгууллагад ажиллагсадын нийгмийн баталгаа хангагдана. | НДБ, Татвар хураагч | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | 7 | СЗДҮАХ-ийн 5.1.11 | 1,2-р багийн Засаг дарга нартай хамтран малчид, ажилгүй иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгааг гарган мөн тэдэнд хууль эрх зүйн сургалт сурталчилгааг явуулах, шинэчилсэн хуулийн талаархи мэдээлэлийг тухай бүр нь иргэдэд мэдээлж тэднийг сайн дурын даатгалд хамруулж ажиллана. | Иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар, болон тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт олголтын талаар мэдээлэлийг нийт давхардсан 425 иргэнд өгч ажиллалаа.<br>НД-ын сайн дурын даатгалд 165 иргэн, ЭМД-д 252 иргэн нийт 417 иргэнийг НД болон ЭМД-д хамрагдсан байна. | Хуулийн мэдлэг хангагдаж даатгалд хамрагдах иргэдийн тоо нэмэгдсэн байна | Нийгмийн даатгалын байцаагч, БЗД нар | ЗДТГ |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГО:** | | | | | | | |
| **2.1 Хөдөө аж ахуйн бодлого:** | | | | | | | |
| 38 | 1 | СЗДҮАХ-ийн 2.1.3 | Монгол улсын “Тариалангийн тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 131-р тогтоолын дагуу тариалангийн талбайд нэн ойрхон өвөлжөө хаваржааг үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. | 2018 оны байдлаар**:** Тариан талбайд 300 м-ээс дотогш байгаа 39 өвөлжөө байна. Үүнээс тариалангийн талбайгаас нүүлгэн шилжүүлсэн-9 өрхийн 3106 толгой мал, гадны аймаг сумруу шилжилт хөдөлгөөн хийсэн 13 өрхийн 6000 орчим толгой мал, зуслан өвөлжөөний газрын давхцалтай гэх шийр орчмын 6 өрхөөс 5 өвөлжөө, мөн зөвшөөрөлгүй баригдсан 3 өвөлжөөг буулган нүүлгэх ажлууд тус тус хийгдсэн. Ашиглалтгүй 9 өвөлжөө / Баюудайд -2, Мангирт -1, Шар хөтөл -1, Хар нүдэн-2, Хөх нүдэнд- 1, Нарст гуу-1, Бор Харгант -1 /шилжсэн/ /байна. | Тариалангийн тухай хуулийн хэрэгжилт хангагдаж газар тариалан эрхлэх малчид тариаланчдын зөрчил багасч га-аас авах ургацын хэмжээ нэмэгдэнэ | Ажлын хэсэг | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | 2 | СЗДҮАХ-ийн 2.1.3 | Газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлж жилд тариалах улаан буудайн хэмжээг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бусад үр тарианы тариалалтыг нэмэгдүүлнэ. | 1 Сумын хэмжээнд 2018 онд улаан буудай 8346 га, бусад үр тариа 40 га, Тосны ургамал 3478 га-д тариалсан. | 1.Улаан буудайн болон бусад үр тарианы тариалалтыг 10000 га-д Улаан буудай болон бусад үр тарианы тариалалт нэмэгдэнэ. | ХАА-н тасаг | ЗДТГ |
| 40 | 3 | СЗДҮАХ-ийн 2.1.7 | Хуучин зоорийг сэргээн засварлах, шинээр зоорь барих саналыг бодлогоор дэмжинэ | 800 тн-ийн багтаамжтай нийт 35 зоорь ашиглагдаж байна. | Зоорийг шинэчлэн засварласнаар багтаамжийг 500 тн-оор нэмэгдүүлэх боломжтой. | ХАА-н тасаг | ЗДТГ |
| 41 | 4 | СЗДҮАХ-ийн 2.1.8 | Шийрийн эртийн ургацын төмсийг зах зээлд сурталчилах ажлыг зохион байгуулна. | 2018 онд 25000 ширхэг шуудай буюу 1000 тн-ийн савлагааг тойргийн УИХ-ын гишүүнд санал тавьсанаар шийдвэрлүүлж намрын хураалтаар 3000 ширхэг буюу 120 тн төмсийг “Сэлэнгэ аймаг Шийрийн төмс” нэртэйгээр зах зээлд борлуулагдсан. | “Сэлэнгэ аймаг Орхон сум Шийрийн төмс” нэртэйгээр зах зээлд борлуулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилан олон нийтэд таниулах ажилд ахиц гарна | ХАА-н тасаг | ЗДТГ |
| 42 | 5 | СЗДҮАХ-ийн 2.1.9 | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Сумын хэмжээнд 21 худаг уст цэг ашиглагдаж байгаа гэсэн судалгаа байна. | Худаг уст цэгийн тоо нэмэгдэх | Багийн Засаг дарга, ХАА-н тасаг | ЗДТГ |
| 43 | 6 | СЗДҮАХ-ийн 2.1.10 | Малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах буюу гадны аймаг сумаас мал оруулахгүй байх бодлогыг баримтлана. | 2018 онд гадны аймаг сумаас мал сүргийн шилжилт хөдөлгөөн хийгдээгүй. Отроор өвөлжсөн малд холбогдох татвар, торгууль тавигдсан. Малын хөлийн даац 2.5 оричм хувиар хэтэрсэн. | Гадны аймаг сумаас шилжин ирэх мал сүргийн хөдөлгөөнд тавих хяналт сайжирна. | БЗД, ХАА-н тасаг | ЗДТГ |
| | 7 | СЗДҮАХ-ийн 2.1.13 | Сүү хөргүүрийн цэг байгуулж хөргөлтийн | Сүү хөргөх хүлээн авах цэг байгуулах талаар УИХ- | Сүү хөргүүрийн цэгтэй болсоноор | БЗД, ХАА-н | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 44 | | | иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг дэмжинэ. | ын гишүүн Д.Эрдэнэбатад санал тавьсанаар APU компаниас Орхон гүүрний дааган дэл зоогийн газрын дэргэд тоног төхөөрөмжөө байрлуулаад байна. Сүү авах явуулын үйлчилгээг Номгон сүү хоршоонд хүсэлт тавьсанаар 42-р зөрлөг, урд зам, сумын төв зэрэг 3 байршилд нийт 52 өрхөөс сүү нийлүүлж байна. | малчидын тогтмол орлого нэмэгдсэн байна. | тасаг | |
| 45 | 8 | СЗДҮАХ-ийн 2.1.16 | Малын өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалт, ариутгал халдваргүйтлийн ажил болон мал эмнэлгийн үйл ажиллагаанд тавьх хяналтыг сайжруулна. | 2018 оны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг вакцинжуулалтын арга хэмжээ 93,8 хувьтай байна. Сумын хэмжээнд 2 малын эмнэлэг ажиллаж байна. | Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг вакцинжуулалтын арга хэмжээг 100%-д хүргэж, | ХАА-тасаг | ЗДТГ |
| 46 | 9 | СЗДҮАХ-ийн 2.2.3 | Орхон хонины удмын санг хамгаалах, үржлийн ажлыг технологийн дагуу явуулж жил бүр зохиомол хээлтүүлэгт оруулна. | 2018 онд 654 толгой “Орхон” үүлдрийн эм хонийг хээлтүүлгэнд хамруулах төлөвлөгөө, судалгаа гарсан. Хийгдэж байна. | Зохиомол хээлтүүлэгт орох эм хонины тоо нэмэгдэж нарийн нарийвтар ноост орхон хонины цөм сүргийн тоо толгой нэмэгдэнэ. | БЗД, ХАА-н тасаг | ЗДТГ |
| 47 | 10 | Иргэдийн санал | Үр тариа, төмс хүнсний ногооны талбайд тавьх хяналтыг сайжруулж, тооллого явуулна. | 2018 онд төлөвлөсөн боловч аймгийн газрын албанаас бүх сумдад нэгдсэн журмаар тус тооллого хийгдэх болсонтой холбоотой хүлээгдэж байна. | Үр тариа төмс хүнсний ногооны талбайн хяналт сайжирна. | Ажлын хэсэг | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | 11 | ХХАХҮЯ, ХЗДХЯ, Сангийн сайд нарын хамтарсан А 136, А159, А 216 тоот тушаал | Тариалангийн талбайд учирсан хохирол тооцох аргачлалыг иргэн, ААН, Малчдад сурталчлан таниулах, малчид тариаланчдын хамтарсан зөвөлгөөнийг зохион байгуулна. | Тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан орсны улмаас учирсан хохиролыг тооцох аргачлал 2018 оны 08 сарын 26 ны өдөр батлагдсан. | Хохирол тооцох аргачлалыг сурталчилж малчид, тарианланчид нэгдсэн мэдээлэл хүрсэн байна. | ХАА-тасаг | ЗДТГ |
| 49 | 12 | Аймгийн үндсэн чиглэл | МУ-д Атар газар эзэмшсэний 60 жилийн ойг аймгийн бодлого төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулна. | Атар газар эзэмшсэний ойд зориулан “Ногоон төгөл ”-ийг тухайн сэдвээр тохижуулах ажлыг газар тариалан эрхэлдэг иргэн аж ахуй нэгжүүдийн дэмжлэгээр гүйцэтгэхээр төлөвлөж байна. | Атар газар эзэмшин ажиллаж байсан үе үеийн тариаланчдын хөдөлмөр зүтгэлийг төр засаг үнэлсэн үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна. | Ажлын хэсэг | ЗДТГ |
| 50 | 14 | ИТХ-ын санал | Тариалангийн талбайн оготно устгалын ажлыг тариалалт эхлэхээс өмнө нэгдсэн удирдлагаар хангах шаардлагатай арга хэмжээ авах | 2018 онд 9124 га тариалангийн талбайд оготно устгалын 18 ААН, 3 иргэн өөрийн хөрөнгөөр хийж хийж гүйцэтгэсэн. Гүйцэтгэл 30 хувьтай байсан. | Тариалангийн талбай эзэмшдэг ААН, иргэдэд албан мэдэгдэл хүргүүлэх, оготно устгалтын ажлыг 60 хувьд хүргэнэ. | ХАА-тасаг | ЗДТГ |
| 51 | 15 | ИТХ-ын санал | Үр тариа, төмс хүнсний ногоо тариалдаг иргэдийн тариалангийн талбайг хашаажуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, хөрсний элэгдэл гэмтлийг бууруулах, хамгаалах ажлыг зохион байгуулах | Тариалангийн болон төмс хүнсний ногооны талбайн 3022 га талбайг хашаажуулсан. Нийт тариалангийн талбайн 12 хувийг хашаажуулсан байна. | Үр тариа төмс хүнсний ногооны хашаажуулах талбайг 30 хувьд хүргэнэ. Малаас тариалангийн талбайг хамгаална. Малчид тариаланчдын хоорондын зөрчил буурна. | ХАА-тасаг | ЗДТГ |
| **2.2 [illegible], ү [illegible]:** Байгаль орчныг хамгаалах талаар гарсан Монгол Улсын хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангаж, байгаль хамгаалах чиглэлээр санал санаачлага гаргасан иргэн, ААН байгууллагыг дэмжиж, “Ногоон Сэлэнгэ” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| | | АЗДҮАХ- | Орхон гол дагуух | Орхон гол дагуух бургасан | Орхон гол дагуух | Багийн ЗД, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 52 | 1 | 1.2.1 | бургасан ойд хортон шавьж устгалын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. | ойд 2013 онд хортон шавьж устгалын ажлыг “Гранд форест” ХХК хийж гүйцэтгэсэн. | бургасан ой хортон шавьжнаас хамгаалагдана. | БОХ-ын Улсын байцаагч, байгаль хамгаалагч | ЗДТГ |
| 53 | 2 | АЗДҮАХ 1.2.3 СЗДҮАХ 2.3.1, | “НОГООН ТӨГӨЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлэн, мод бут тарих, ургуулсан модоо арчилж тордох, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ. | 2018 онд 1114 мод тарьж үүнээс ногоон төгөлийн хүрээнд монос, хайлаас, шар хуайс, шинэс, нохойн хүшуу, улиас зэрэг 282 ширхэг мод, төр төсвийн байгууллагад 125 ширхэг суулгац, сумын 119 айл өрхөд 599 модны суулгац өгч тариулах ажлыг зохион байгуулсан. Мөн иргэн н.Хишигчулууны үр хүүхэд 0,2 га талбайд 108 ширхэг Голт бор мод тарьж суулган хашаажуулсан. Сумын төвийн хойд хэсэгт 10 га газарт ойн зурвас байгуулах ажлыг Өргөн сэлэнгэ ХХК-иар гүйцэтгүүлж 6000 ширхэг навчит мод таригдсан | Албан байгууллага, ААН, айл өрх, сумын нутаг дэвсгэрийн ногоон байгууламж нэмэгдэж цөлжилтөөс хамгаалагдана . | Багийн ЗД, БОХ-ын Улсын байцаагч, байгаль хамгаалагч | ЗДТГ |
| 54 | 3 | АЗДҮАХ 1.2.4, СЗДҮАХ 2.3.5, | Сумын нутаг дэвсгэрт байгаа булаг шандны эхийг хамгаалалтанд авч засаж тохижуулах ажлыг нутгийн иргэдийн оролцоотойгоор гүйцэтгэнэ. | 2018 онд Нам-Ухаагийн булгийн эхийг хашиж хамгаалах ажил хийгдсэн. Цаашид Бэлэндалай булгийн эхийг хашиж хамгаалах шаардлагатай. | Сумын нутаг дэвсгэрт байгаа булаг шанд хамгаалагдаж усны түвшин нэмэгдэнэ. | БЗД, БОХУБ, БХ | ЗДТГ |
| 55 | 4 | АЗДҮАХ-3.1.25, СЗДҮАХ 2.3.3 | Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ойн сан, байгаль орчныг хамгаалах чиглэлээр идэвхитэн байгаль хамгаалагчидтай | 2018 онд сумын хэмжээнд ой хээрийн түймэр гараагүй цаашид урьдчилан сэргийлэх ажлыг үргэлжлүүлэх шаардлагатай. | Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлж, ойн сангийн хамгаалалт сайжирч ой хээрийн түймрийн гаралт багасна. | БЗД, БОХУБ, БХ | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хамтран хуурайшилттай үед морьт эргүүл ажиллуулна. | | | | |
| 56 | 5 | СЗДҮАХ 2.3.3 | Хууль бусаар мод бэлтгэх, хулгайн ан хийх явдлыг таслан зогсоох, байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тууштай тэмцэнэ. | Тайлант онд зөвшөөрөлгүй мод бэлтгэсэн 1 иргэнд эрүүгийн хэрэг үүсч тэнсэн харгалзах ял, зөвшөөрөлгүй загас барьсан 1 иргэнд 50000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцогдсон. | Байгууллага, иргэд, аж ахуй нэгж, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны түвшин дээшилсэн байна. | Цагдаагийн алба, БОХУБ, Байгаль хамгаалагч | ЗДТГ |
| 57 | 6 | СЗДҮАХ 2.3.4 | Шийр сууринд хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулна. | Хуучин ашиглаж байсан хогийн цэг нь дарж булсан шинээр хогийн цэг байгуулах шаардлагатай. | Суурин газрын өнгө үзэмж сайжирч орчны бохирдол буурсан байна. | Багийн ЗД, БОХ-ын Улсын байцаагч, байгаль хамгаалагч | ЗДТГ |
| 58 | 7 | СЗДҮАХ-ийн 2.3.6 | Сумын төвд хөрсний эвдрэлд орсон зарим газарт ногоон зурвас байгуулах ажлыг хийж гүйцэтгэнэ. | 2018 онд 10 га талбайд ногоон зурвас байгуулах ажлыг “Өргөн Сэлэнгэ” ХХК гүйцэтгэсэн. | Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэж хөрсний элгэдэлд орсон талбайн ашиглалт хамгаалалт сайжирна. | БОХУБ, БХ | ЗДТГ |
| 59 | 8 | СЗДҮАХ 3.1.8 | Сумын хэмжээнд ундны усны зориулалтаар ашиглагдаж буй гүний худгуудын усыг шинжилгээнд хамруулах. | 2018 онд аймгийн МХГ-ийн лабораторид сумын төвийн гүний худаг, ЭМТ, 12-р цэцэрлэг, ЕБС –ийн ундны усыг шинжилгээнд хамруулсан. | Эрүүл ахуйн шаардлага хангасан усаар иргэд, ААН-д үйлчилнэ. | БОХУБ | ЗДТГ |
| **<u>2.3 Төсөв санхүүгийн бодлого шинэчлэлийн хүрээнд:</u>** с[illegible], [illegible], [illegible], [illegible] ү [illegible], [illegible], төсвийн орлогыг нэмэгдүүлэн *төсөв санхүүгийн ил тод байдлыг хангана.* | | | | | | | |
| 60 | 1 | АЗДҮАХ-ийн 1.5.1 | Төсөв, орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн төлөвлөлт, | 2018 оны ОНХС-н хөрөнгөөр 48137,2 мянган төгрөгийн ажил хийхээр төлөвлөгдсөн. | 2019 онд хэрэгжих төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл болон төлөвлөгөөнд | Санхүүгийн алба | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зарцуулалтын хяналтанд олон нийтийн оролцоог хангаж, хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажил, үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлнэ. | | иргэдийн оролцоо хяналт сайжирна. | | |
| 61 | 2 | АЗДҮАХ-ийн 1.5.2 | Татвар төлөгчийн хүрээг өргөтгөж, татвар хураалтыг сайжруулан, орон нутгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ. | 2018 оны 3-р улирлын байдлаар :<br>Хувь хүний орлогын албан татвар 58.2 , Иргэний ҮХХБорАТ 42.7, Галт зэвсгийн албан татвар 63.6, Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 7.5, Байгалын ургамал ашигласны төлбөр 557 хувийн гүйцэтгэлтэй байна. | Татварын орлогыг батлагдсан хуваарийн дагуу 100% хангаж биелүүлж орон нутгийн төсвийг бүрдүүлнэ. | Татвар | ЗДТГ |
| 62 | 3 | АЗДҮАХ-ийн 1.5.4 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төсвийн ил тод байдлыг хангана. | Шилэн дансны цахим хуудсанд /shilendans.mn / сар бүрийн 8 ний дотор мэдээллийг байршуулж 692 удаагийн мэдээлэл оруулсан байна. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлснээр төсвийн ил тод байдал сайжирна. | Санхүүгийн алба | ЗДТГ |
| 63 | 4 | АЗДҮАХ-ийн 1.5.5 | Статистик мэдээ, мэдээллийн үнэн зөв бодит байдал, чанарыг дээшлүүлж, олон нийтэд нээлттэй хүртээмжтэй ажиллана. | Статистик мэдээ тайланг графикт хугацаанд гаргаж, ХАА-н тасаг, багийн засаг дарга болон мэдээлэл цуглуулж буй аж ахуйн нэгж, иргэн бүртэй хамтран ажиллаж Статистикийн хэлтэст 17 төрлийн 61 удаагийн давтамжтай мэдээллийг үнэн бодитой гарган архив үүсгэн хадгалж ажилласан. Мөн статистикийн мэдээ мэдээллийг цаг алдалгүй тухай бүрт нь иргэдэд | Статистикийн мэдээ мэдээллийг тухай бүрт авснаар иргэд үнэн зөв мэдээллээр хангагдана. | Төрийн сангийн мэргэжилтэн | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүргэх байдлаар ханын самбарт байршуулан ажилласан. | | | |
| | **ГУРАВ. ДЭД БҮТЭЦ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО** | | | | | | |
| 64 | 1 | СЗДҮАХ-3.1.3 | Орхон сум байгуулагдсаны 60 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөөний дэд бүтэц бүтээн байгуулалтын ажлуудыг хийж гүйцэтгэнэ. | Ойг угтсан нэгдсэн төлөвлөгөөг ИТХ-аар батлуулан ажиллаж байна. Атар газар эзэмшсэний 60 жилийн ойд зориулан тохижуулах, сумын үүсэл хөгжил цаг үеийн мэдээ мэдээлэл, алдартнууд гэсэн 3хэсэг бүхий самбарын хийх ажлын зураг хийгдсэн. | Ойн хүрээнд хийгдэх сумын онцлогийг харуулсан бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна. | Ажлын хэсэг | ЗДТГ |
| 65 | 2 | СЗДҮАХ-ийн 3.1.4 | 42-р зөрлөгөөс Шийр суурин хоорондын сайжруулсан замуудыг холбох, Бороочийн амны замыг засах | 2017 оны аймгийн замын сангийн хөрөнгөөр 1.6 км авто замыг засч, намагшсан хэсгүүдэд шинээр хайрган хучилттай зам зассан. 2018 оны бороны улиралд 2 сайжруулсан замын дундах шороон замд эвдрэл үүсч ногооны тээврийн ажилд хүндрэлтэй байдаг. | Шийр 42-р зөрлөг, Бэлэндалай орчимд үр тариа, төмс хүнсний ногоо эрхэлдэг иргэн ААН-үүдийн ургац тээврийн үед үүсдэг хүндрэлүүд багасна. | Ажлын хэсэг | ЗДТГ |
| 66 | 3 | СЗДҮАХ-ын 3.1.13 | Загас, загасан бүтээгдэхүүний худалдаа эрхлэгчдийн орчин нөхцөлийг сайжруулна. | 2018 оны байдлаар 5 цэгт 16 иргэн тогтмол хувиараа хөдөлмөр эрхэлж байна. | Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн ажиллах орчин нөхцөлд ахиц гарна. | Ажлын хэсэг | ЗДТГ |
| 67 | 4 | Иргэдийн санал | 1. Шийрийн улаан буланд урсгал засвар хийж хашаажуулж,<br>2. Багийн болон эмч нарын байранд урсгал засвар хийнэ. | Дусаал гоожиж мөөгөнцөртсөн, урсгал засвар хийж хашаажуулах шаардлагатай. | Тухайн хэсгийн иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх, цаг үеийн мэдээлэл, багийн хурал хийхэд орчин нөхцөл сайжирна. | Ажлын хэсэг | ЗДТГ |
| **ДӨРӨВ. НУТГИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО** | | | | | | | |

**4.1*Төрийн захиргаа, хууль эрх зүйн бодлого, ү □□□□□□□□□ хүрээнд:***

*Шийдвэр гаргах түвшинд иргэд олон нийтийн оролцоог хангах нөхцөл боломжийг бүрдүүл□, □өрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдлыг ханга□ □□ □□□□ □□□□□□□□□ □□□□□□□□□, □□□□□ □□□□ □□□□□□□ □□□□□□ □□□□□□□□□□□□ү □□□□□.*

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 68 | 1 | Иргэдийн санал | МУЗГ-ын 2018 оны 258 тоот “ТӨРИЙН АЛБАНЫ САХИЛГА ХАРИУЦЛАГА, ДЭГ ЖУРМЫГ ЧАНГАТГАХ ТУХАЙ” албан даалгаврын хэрэгжилтийг хангаж төрийн албан хаагчдийн сахилга хариуцлагыг сайжруулах | Албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор 10 заалт бүхий төлөвлөгөө гарган төр төсвийн байгууллагуудад үүрэг чиглэл өгсөн. | Төрийн албаны ажлын хариуцлага, цаг ашиглалт, сахилга бат сайжирч иргэдэд төрийн үйлчилгээ чирэгдэлгүй хүрсэн байна. | ЗДТГ-ын дарга | ЗДТГ |
| 69 | 2 | СЗДҮАХ-ийн 4.3 | www.selengeorkhon.mn вэб хуудастай болж сумын танилцуулга, цаг үеийн мэдээ мэдээлэл, төсөв санхүү, хүний нөөцийн, худалдан авах ажиллагаа болон бусад төр төсвийн байгууллагын мэдээ, мэдээллийг байршуулж мэдээллийн ил тод байдлыг бий болгоно. | Цахим хуудас ашиглалтанд орсон боловч мэдээлэл оруулж буй албан хаагч солигдсонтой холбогдуулан хариуцсан албан хаагчийн мэдлэгийг сайжруулах шаардлагатай. | Албан ёсны цахим хуудасны ашиглалт сайжирч шаардлагатай мэдээллийг цахимаар хүргэдэг үйлчилгээ тогтмолжсон байна. | ТЗХЭАХМ | ЗДТГ |
| 70 | 3 | СЗДҮАХ-ийн 4.5 | Төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавьх хяналтыг сайжруулж төлөвлөгөөт шалгалт зохион байгуулна. | ЗДТГ-аас 2018 оныг дотооддоо “Хариуцлагатай чадварлаг төрийн албан хаагчийг төлөвшүүлэх жил” болгон зарлаж улирал тутам төлөвлөгөөт шалгалтыг хийж байна. | Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, албан бичиг хэрэг хөтлөлт, дотоод зохион байгуулалт сайжирна. | Ажлын хэсэг | ЗДТГ |
| 71 | 4 | СЗДҮАХ-ийн 4.9 | БИНХ-ыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна. | 2017 онд 1 удаа БИНХ зохион байгуулагдсан. Хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай. | Иргэд цаг үеийн мэдээллээр хангагдаж, төрийн үйлчилгээний хүртээмж дээшилнэ. | БИНХ, БЗД нар | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 72 | 5 | СЗДҮАХ-ийн 4.11 | Төрийн албан хаагчийг чадавхижуулах хариуцлага болон урамшууллын тогтолцоог сайжруулна. | 2018 онд “Хариуцлагатай чадварлаг төрийн албан хаагчийг төлөвшүүлэх жил” -ийн хүрээнд ТАХ-ын тухайн жилийн ажлыг үнэлэх “Үнэлгээний хуудас” боловсруулж хагас бүтэн жилээр үр дүнг тооцож, аяны хүрээнд бичиг хэргийн эмх цэгц, өгсөн үүрэг даалгаврын биелэлт зэргийг хянаж байна. | ТАХ-ын албан бичиг төлөвлөлт, эмх цэгц, үүрэг даалгаврын хөтлөлт, биелэлт, хувь хүний хөгжил, хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ. | Ажлын хэсэг | ЗДТГ |
| 73 | 6 | АЗДҮАХ-ийн 2.5.9 | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах ажлыг сайжруулна. | Насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргийн гаралт 2018 онд нэмэгдсэн. | Насанд хүрээгүй хүүхдийн гэмт хэргийн гаралт буурсан байна. Эцэг эхийн оролцоо нэмэгдэж эрсдлээс урьдчилан сэргийлэгдэнэ. | ЕБС, ЗДТГ, Хамтарсан баг | ЗДТГ |
| **4.2 Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хангах, авлигаас урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээ** | | | | | | | |
| 74 | 1 | СЗДҮАХ-ийн 4.12 | Хууль бусаар мод бэлтгэх, хулгайн ан хийх явдлыг таслан зогсоох, зөрчлийн тухай мэдээллийг урамшуулах тогтолцоог бүрдүүлэх. | Хууль бусаар мод бэлтгэх, хулгайн ан хийх явдал гарсаар байна. | Гэмт хэргийн гаралт буурна. | Цагдаагийн хэсэг, БОХУБ | ЗДТГ |
| 75 | 2 | СЗДҮАХ-ийн 4.14 | Авилга, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон хөдөлгөөн өрнүүлнэ. | Авлигагүй нийгмийн төлөө жилийн аяныг зохион байгуулсан. | Авлигаас урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо нэмэгдэж, хөндлөнгийн хяналттай болно. | ТЗХЭАХМ | ЗДТГ |
| 76 | 3 | АЗДҮАХ 3.2.8 | Архидалттай тэмцэх аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж согтуугаар үйлдсэн гэмт хэргийн тоог бууруулах | 2018 оны 3-р улиралын байдлаар согтуугаар үйлдсэн гэмт хэрэг өмнөх оноос 10 хувиар буурсан байна. | Согтуугаар үйлдсэн гэмт хэргийн гаралт буурч, иргэдийн аюулгүй, амар тайван байх эрх | Цагдаагийн хэсэг | ЗДТГ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамгаалагдана. | | |
| 77 | 4 | АЗДҮАХ 3.2.11 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулах, идэвхтэн байгаль хамгаалагчийг урамшуулах | Малын хулгайн гэмт хэрэг 2018 онд 1 бүртгэгдээд байна. | Гэмт хэргийн гаралт буурсан байна. | Цагдаагийн хэсэг | ЗДТГ |

Засаг даргын Тамгын газар